

## ИХ ЗОХИОЛЧ ЛҮ ШҮНЬ

ЧОЙ. ЛУВСАНЖАВ\*

Хятадын их зохиолч Лү Шүнь 1881 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр Хятадын Жэ жиан мужийн Шао шин хэмээх тосгонд төрөөд 1936 оны 10 дугаар сарын 19-нд Шанхай хотноо бие баржээ. 1961 онд энэ их зохиолчийн төрсний 80 жилийн ой, нас барсны нь 25 жилийн ой болсон билээ. Лү Шүнь бага наснаасаа тариачдын хүүхэдтэй үерхэж тариачдын аж амьдрал, зовлон зүдүүрийг мэддэг болсон нь түүний уран бүтээл, бодол санаанд сайн нөлөө үзүүлсэн байна. Лү Шүнь бага насаа төрсөн тосгондоо өнгөрөөгөөд 1898 онд Нанжин хотноо эрдэм сурахаар одож, улмаар 1902 онд Япон улсад анагаах ухааны дээд сургуульд явжээ.

Эх орноо аврая гэвэл хүн ардынхаа оюун санаанд эргэлт хийж, үндэстнийхээ ухаан бодлыг сэргээн дэвжүүлэх нь эрхбиш зүйтэй хэрэг гэгчийг залуу Лү Шүнь зөв ухааран, анагаах ухаан сурах гэсэн бодлоо эрслэн орхиод уран зохиол оролдож эхэлжээ.

Лү Шүнь 1919 онд эх орондоо эргэж ирээд хэдэн жил хөдөөний тариачдын хүүхэд багачуудад эрдэм ном заан явжээ.

1911 оны хувьсгалын дараахан тэр цагийн Хятадын Гэгээрлийн Яамнаа албан хааж байх зуураа Бээжингийн их сургууль зэрэг томоохон сургуулиудад багшлах ажил хавсран хийж байлаа. 1918 оноос эхлэн олон тооны зохиолоо хэвлүүлж бийрийнхээ хурц үзүүрийг хамжлагат ёсны бурангуй дэглэм болон зүсэн бүрийн харийн түрэмгийлэн эзлэгчдийн эсрэг чиглүүлжээ. Лү Шүний бичсэн “Галзуу хүний өдрийн тэмдэглэл” гэдэг зохиол бол тэр үед хамгийн анх ардын хэлээр бичсэн зохиол байжээ.

Эх орны нь ариун газар шороог бузар хөлөөрөө гишгэчиж төр эрхий нь ноёлж удаан жилийн уламжлал, далай баялаг соёлы нь нулиман дээрэлхэж, оюун билэгт хүн арды

нь мунхаг зэрлэг хэмээн доромжилж заншсан уран ганган үгтэй, хорон өмхий санаатай харийн хомхой эзлэгчдийг эсэргүүцэн эх орон, ард түмнээ өрөвдөн хайрлаж, өвөг дээдсийнхээ гал голомтыг харгисуудаар хэзээ ч түйвээлгэхгүйн тулд зориг сэтгэл нэгдэн боссон Бээжингийн оюутан залуусын 1919 оны 5 дугаар сарын 4-ний түүхт хөдөлгөөнд Лү Шүнь манлайлан оролцож байжээ.

Эрх ямбаар эх орноо арилжсан Хятадын цэргийн эрхтнүүд 1926 онд оюутан залуучуудын эх оронч хөдөлгөөнийг цус урсган дарсныг Лү Шүнь хурцаар шүүмжлэн “3 дугаар сарын 18” зэрэг олон зохиол бичжээ. Хожим, Сүн Ятсений нэрэмжит их сургууль зэрэг газар багшилж байгаад Лү Шүнь 1930 онд “Хятадын зүүн жигүүрийн зохиолчдын холбоо” гэгчийг үүсгэн байгуулсан байна.

Лү Шүнь амьдралынхаа сүүлийн арваад жил Шанхайд байхдаа олон тооны өгүүллэг, нийтлэг өгүүлэл, ёгтлол бичсэн нь Хятадын орчин үеийн дэвшилт уран зохиолын үндэс суурь болжээ.

Лү Шүний энх тунх байсан цаг үе бол хятадын ард түмэн харийн түрэмгийлэн эзлэгчид болон феодалын бурангуй ноёрхлын эсрэг тэмцэж байсан хатуу ширүүн тэмцлийн үе байлаа. Лү Шүнь тэр хатуу ширүүн тэмцэлд идэвхтэй оролцож эх болсон ард олноо элэг зүрхнээсээ хайрлаж харийн дайсныг үнэн голоосоо занан үзэхийн сэтгэлээр зохиолоо бичдэг байв.

Лү Шүнь, Хятадын ард түмэнд оюун санааны болон соёлын баялаг өв үлдээжээ.

Лү Шүнийг бие барснаас хойш “Лү Шүнийг дурсах хороо” гэгч эрхлэн зохиолы нь эмхлэн гаргасан. 1941 онд мөн хорооноос Лү Шүний 30 жил бүтээсэн бүтээлий нь эмхтгэн хэвлүүлжээ.

\*Чой.Лувсанжав- Монгол Улсын гавъяат багш, доктор, профессор

Хятадад ардын хувьсгал мандсанаас хойш 1956 онд Лү Шүний зохиолуудыг 10 ботиор хэвлэж мөн гадаад хэлнээс орчуулсан зохиол, өдрийн тэмдэглэл зэргий нь эмхлэн цэгцэлж хэвлүүлсэн байна.

Лү Шүнь япон, герман, орос зэрэг хэлнээс олон тооны зохиол орчуулж хэвлүүлсэн ажээ. 1961 оны бүрэн бус мэдээгээр Лү Шүний зохиол 28 улсын 32 хэлээр орчуулагдан гараад байна. Манай монгол хэлээр “Галзуу хүний өдрийн тэмдэглэл”, “А-киу-гийн үнэн түүх”, “Төрөлх суурин”, “Фүжи но багш” зэрэг түрүүхэн үеийн гол гол зохиолы нь орчуулан хэвлэжээ.

Лү Шүнь амьдралынхаа турш залуучуудын төлөө ямагт санаа тавьж тэдэнд их итгэн найдаж залуу зохиолчдын зохиолыг цаг, бие юүгээн үл хайрлан уншиж танилцан засаж залруулж зөвлөлгөө сургамж өгдөг хүн байжээ.

Лү Шүний зохиолыг хөнгөн хуумгай уншиж өнгөрөх ахул доторхи далд гүнзгий

утгаг мөчид ухах буюу ойлгохгүй явдал гарч болох талтай. Учир нь: 1. Ард түмний төлөө хатан зоригоор тэмцэгч Лү Шүнийг дайснууд нь элдэв аргаар хяхан хавчиж хөнөөн хороохыг оролдож байсан үес Лү Шүнь арга буюу олон зохиолоо битүү далд утгаар ёжлон бичсэн ажээ.

2. Харьяат ард, улс үндэстнийхээ нутаг газраас нь авахуулаад хүн ардынхаа зан заншил, ёс суртахуун, түүх соёл тэргүүнийг нэвтэрхий мэдэж, тэгснээрээ зохиолоо өөрийн орны онцлог зүйлстэй нарийн чадмаг холбож бичсэн байдаг тул хятад орны байдлыг бага мэдэх уншигч хүн ухах мэдэхэд хэцүүвтэр тал бас нилээд байж болохыг зориуд тэмдэглэж байна.

Жич: манай нэрт нанхиадач Чой. Лувсанжав, Д.Бандихүү нар Лү Шүний зохиолоос орчуулан “Мөнх гийгч дэнлүү” нэртэйгээр 1962 онд хэвлүүлсэн орчуулгын эмхэтгэлээс авав.